



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5/01

Өмнөдэлгэр сум

**Эрүүл мэндийн төвийн даргаар
Ц.Ариунтунгалагийг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 56 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", 7 дугаар хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн, салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Хоринзургаа дугаар хуралдааны 01 дүгээр тогтоол, Хэнтий аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2025 оны 80 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 05/21352 тоот албан бичгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн тул Цэцэгсайханы Ариунтунгалагийг 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс Эрүүл мэндийн төвийн даргаар томилсугай.

2. Холбогдох хууль, дүрэм журам, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартыг чанд мөрдөн, албан тушаалын тодорхойлолтоор

2325310004

D:\disk\bichig hereg/ zahiramj/

хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, идэвх санаачилгатай ажиллахыг Ц.Ариунтунгалагт үүрэг болгосугай.

3. Ц.Ариунтунгалагийг үндсэн цалин ТҮЭМ-6 1,559,000 (нэг сая таван зуун тавин есөн мянга) төгрөгөөр, орон нутгийн нэмэгдлийг 40 хувь, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 13 хувь, ажил хавсарсаны нэмэгдэл 30 хувь, салбарын нэмэгдэл 60 хувиар тооцож цалинжуулахыг нягтлан бодогч (Б.Сэр-Од)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Б/29 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Р.ЭНХТӨР